



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны нэгдүгээр сарын 22

№3 (141)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

- | | | |
|---|-----------|----|
| 21. Зарим шүүгчийг чөлөөлөх тухай | Дугаар 03 | 45 |
| 22. Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай | Дугаар 04 | 45 |
| 23. Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай | Дугаар 05 | 46 |

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

- | | | |
|---|------------|----|
| 24. Мардайн ураны Эрдэс үйлдвэр, тосгон, дэд бүтцийн талаар авах арга хэмжээний тухай | Дугаар 190 | 46 |
| 25. Хувьцаат компаниуд үүсгэн байгуулж, хувьчлах тухай | Дугаар 191 | 47 |

Гурав. Яам, агентлагийн акт

- | | | |
|--|--------------|----|
| 26. Журам батлах тухай (Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын тушаал) | Дугаар А/168 | 50 |
|--|--------------|----|

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Зарим шүүгчийг чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөр шүүхэд ажиллах болсонтой холбогдуулан Лхамжавын Сарангэрэлийг Нийслэлийн Хан-уул дүүргийн шүүхийн шүүгчийн, Тогтохын Ураншэцгийг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн,

тэтгэвэрт гарах болсон тул Тавхайн Жигжидсүрэнг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Лхамжавын Сарангэрэлийг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Гомбын Лхагвамааг Өвөрхангай

аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчийн, Тогтохын Ураншэцгийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай

1. Монгол Улсаас Испани Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Готовдоржийн Луузанг томилсугай. Испани Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ** Хасбазарын Бэхбатыг Монгол Улсаас

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Мардайн ураны Эрдэс үйлдвэр, тосгон, дэд бүтцийн талаар авах арга хэмжээний тухай

БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд байгуулсан "БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ураны ордуудыг ашиглах тухай" 1981 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хэлэлцээрийг цуцалж Мардайн ураны Эрдэс үйлдвэрийн үндсэн хөрөнгө, дэд бүтэц, уурхай, нийгэм соёлын объектууд болон Мардайн бүлэг ордуудын геологийн баримт бичгүүдийг Монголын талд хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мардайн ураны Эрдэс үйлдвэрийн үндсэн хөрөнгө, дэд бүтэц, уурхай, нийгэм соёлын объектуудыг ураны үйлдвэрлэлд хөрөнгө оруулж хамтран ажиллах асуудлыг шийдэх хүртэл түр хамгаалж хадгаламжийн горимд бүрэн бүтэн байлгах, нийгмийн хэв журмыг сахиулах зорилгоор цагдаагийн тусгай анги зохион байгуулж ажиллуулахыг Хууль зүйн сайд Д.Ганболд, Дорнод аймгийн Засаг дарга Л.Сүхбаатар нарт даалгасугай.

2. Мардайгаас ОХУ-ын хил хүртэлх өндөр хүчдэлийн цахилгааны шугам, дэд станцыг дотоод шугам сүлжээний хамт, мөн төмөр замыг хүлээж авч ашиглалтын болон хадгалалт хамгаалалтын горимд мэргэжлийн байгууллагаар хяналт, үйлчилгээ хийлгэж ажиллах буюу шаардлагатай гэж үзвэл уг байгууламжийн зарим хэсгийг буулгаж материалыг нөөцөнд түр хадгалах, худалдах арга хэмжээ авахыг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү, Мардайн ураны хүдрийн ил, далд уурхай, уусгахаар бэлтгэгдсэн овоолго, талбай болон тэдгээрийн холбогдолтой байгууламжуудыг хадгаламжийн горимд байлгаж мэргэжлийн хяналт тавих байнгын

төлөөлөгч ажиллуулахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн нарт тус тус даалгасугай.

3. Мардайн ураны бүлэг ордод хайгуул хийхээс эхлэн Эрдэс үйлдвэрийг байгуулж хүдрийг олборлох үйл ажиллагааг явуулснаас байгаль орчинд үзүүлсэн нөлөөлөл, үүнээс цаашид үүсч болох аливаа сөрөг үр дагавар, хадлан бэлчээр, мал аж ахуй, хүн амын эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж болох талаар нарийвчилсан үнэлгээ, дүгнэлтийг 2000 оны эхний хагаст багтаан гаргуулж, байнгын хяналт ажиглалт хийж ажиллахыг Байгаль орчны сайд С.Мэндсайхан, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонин, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн нарт даалгасугай.

4. Мардай орчмын газар нутгийн байршил, дэд бүтцэд түшиглүүлэн зүүн бүсийн хилийн худалдааны чөлөөт бүсийг байгуулах, сум дундын соёл, үйлчилгээний төвийг байгуулах болон засаг захиргааны тусгай нэгжийг буй болгох боломж нөхцөлүүдийг судалж санал, төсөл боловсруулж Мардайн тосгонд байгаа усан хангамжийн систем, мазутын зуух, дулааны шугам, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, соёлын ордон, дэлгүүр зэрэг нийгэм соёл, ахуй хангамжийн объектуудыг ашиглах, хадгалж хамгаалахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай санал, тооцооны хамт энэ онд багтаан Засгийн газарт оруулахыг Дорнод аймгийн Засаг дарга Л.Сүхбаатарт даалгасугай.

5. Монгол-Орос-Канадын аж ахуйн байгууллагуудын хооронд хийсэн гэрээний дагуу байгуулагдсан хамтарсан "Төв Азийн уран"



компанийн статус, гэрээ хэлэлцээрийн хууль эрх зүйн үндэслэл, Эрдэс үйлдвэрийн бүх өмчийг Монголын талд хүлээж авахтай холбогдуулан компанийн дүрмийн сан, талуудын хувь оролцоо, хөрөнгө оруулалт, санхүүжилт зэрэг асуудлаар судалгаа дүгнэлт гаргах, Канадын талаас оруулсан хөрөнгийн зарцуулалтыг энэ онд багтаан албан ёсоор нарийвчлан гаргуулж авахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Гадаад харилцааны сайд Н.Туяа, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт даалгасугай.

6.Мардайн тосгонд байгаа дээр дурдсанаас бусад барилга байгууламж, үндсэн хөрөнгийг Монголын талд хүлээж авсны дараа хувьчлах, худалдах, түрээслэх, хадгаламжид түр байлгах болон бусад хэлбэрээр зохицуулах, Батлан хамгаалах яамны хүсэлтийг үндэслэн Мардайн тосгонд байгаа "БАМ"-ын хийцийн байшингуудаас шаардлагатай тооны байшинг Хилийн цэргийг удирдах газрын балансад шилжүүлэх асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, энэ тогтоолын 2 дугаар заалтад дурдсан өмч хөрөнгийг холбогдох газруудад балансаар хүлээлгэн өгч ашиглалт, хамгаалалтын

байдалд хяналт тавьж ажиллах, шаардлагатай гэж үзвэл энэ ажлыг хариуцсан төлөөлөгчийн газар буюу ашиглалтын өмнөх захиргааг байгуулж ажиллуулахыг Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригтод зөвшөөрсүгэй.

7.Мардайн тосгон, дэд бүтэц, уурхай, үндсэн хөрөнгийг ашиглах, хамгаалах, түр хадгалах, хувьчлахад гарах зардлыг түр санхүүжүүлэх зорилгоор 1999-2000 онд хувьчлах төлөвлөгөө, төсөвт тусгагдаагүй объектыг хувьчлахаас улсын төсөвт орох орлогын болон Мардайн зарим үндсэн хөрөнгийг худалдаж хувьчлахаас орох орлогын тодорхой хувийг хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг Сангийн сайд Я.Очирсүх, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд	Р.АМАРЖАРГАЛ
Сангийн сайд	Я.ОЧИРСҮХ
Дэд бүтцийн хөгжлийн сайд	Г.БАТХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Хувьцаат компаниуд үүсгэн байгуулж, хувьчлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Татан буугдсан "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонины өмчийг хувьчлах тухай хууль, "Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 1999 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Татан буугдсан "Ардын эрх" сонины хөрөнгөд үндэслэн хувьцаат компанийг үүсгэн байгуулж, тус компанийн дүрмийн сангийн хэмжээг 201,470,000 / хоёр зуун нэг

сая дөрвөн зуун далан мянган/ төгрөгөөр тогтоосугай.

2.Татан буугдсан "Засгийн газрын мэдээ" сонины хөрөнгөд үндэслэн хувьцаат компанийг үүсгэн байгуулж, тус компанийн дүрмийн сангийн хэмжээг 169,577,000 /нэг зуун жаран есөн сая таван зуун далан долоон мянган/ төгрөгөөр тогтоосугай.

3.Татан буугдсан "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонины өмчлөлд байсан хөрөнгөд үндэслэн байгуулагдсан хувьцаат компаниудыг хувьчлах журмыг хавсралтын ёсоор баталсугай.

4.Шинээр үүсгэн байгуулагдсан хувьцаат



компаниудын нийт хувьцааны тоо, нэгж хувьцааны нэрлэсэн үнийг тогтоож, тэдгээрийн 40 хувийг татан буугдсан "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонинд ажиллаж байсан ажиллагсад давуу эрхээр буюу хувьцааны доод үнээр санал болгож, 60 хувийг сонин, хэвлэл эрхлэн гаргадаг хуулийн этгээд, иргэдэд хязгаартай дуудлагын худалдаагаар тус тус худалдахыг Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригтод даалгасугай.

5.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

Монгол Улсын

Ерөнхий сайд

Р. АМАРЖАРГАЛ

Сангийн сайд

Я.ОЧИРСҮХ

Засгийн газрын 1999 оны 191 дүгээр тогтоолын хавсралт

ТАТАН БУУГДСАН "АРДЫН ЭРХ", "ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" СОНИНЫ ӨМЧЛӨЛД БАЙСАН ХӨРӨНГӨД ҮНДЭСЛЭН ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ХУВЬЦААТ КОМПАНИУДЫГ ХУВЬЧЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Энэхүү журмын зорилго нь татан буугдсан "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонинуудын /цаашид "сонин" гэх/ өмчлөлд байсан хөрөнгөд үндэслэн үүсгэн байгуулагдсан хувьцаат компаниудыг /цаашид "компани" гэх/ хувьчлахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2.Төрийн өмчийн хороо нь сонин тус бүр дээр хувьчлах ажлыг зохион байгуулан явуулах Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг томилж ажиллуулна.

3.Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчид үйл ажиллагаандаа "Татан буугдсан "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонины өмчийг хувьчлах тухай

хууль"-ийг удирдлага болгон ажиллана.

4.Засгийн газраас баталсан дүрмийн сангийн хэмжээ нь тус компаниудыг хувьчлах доод үнэ болно.

5.Компаниудын нийт хувьцааны 40 хувийг "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонинуудад ажиллаж байсан, давуу эрхээр хувьцаа худалдан авах эрх бүхий этгээдэд санал болгох замаар худалдана.

6.Давуу эрхээр хувьцаа худалдах ажиллагаа дууссаны дараагаар тус компанийн нийт хувьцааны 60 хувийг сонин, хэвлэл эрхлэн гаргадаг хуулийн этгээд, иргэдэд хязгаартай дуудлагын худалдаагаар худалдана.

Хоёр. Давуу эрхээр хувьцаа худалдан авах эрх бүхий этгээдийг бүртгэх, хувьчлалд оролцох эрх олж авах

7."Давуу эрхээр хувьцаа худалдан авах эрх бүхий этгээд" гэдэгт "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонинууд үүсгэн байгуулагдсанаас эхлэн татан буугдах хүртэлх хугацаанд ажиллаж байсан нийт ажиллагсдыг /цаашид "ажиллагсад" гэх/ ойлгоно.

8.Ажиллагсад бүртгэлд бүртгүүлснээр хувьчлалд давуу эрхтэйгээр оролцох эрх

олж авна.

9.Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь өөр өөрсдийн хариуцсан сонинд ажиллаж байсан нийт ажиллагсдын жагсаалтыг гаргаж бүртгэлийн ажиллагааг явуулна. Бүртгэх хугацаа, байршил, бусад шаардлагатай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

10. Сонинуудын ажиллагсад нь зарлагын дагуу дараахь бичиг баримтыг бүрдүүлсний үндсэн дээр бүртгүүлнэ:

а/иргэний паспорт;

б/нийгмийн даатгалын шимтгэлийн дэвтэр, эсвэл хөдөлмөрийн дэвтэр;

в/сонинуудад ажилд орсон болон халагдсан тухай тушаал.

Эдгээр сонины аль алинд ажиллаж байсан хүмүүс хоёр компанийн

хувьцаанаас худалдан авч болно. Ажиллагсад санал болгох хувьцааны тоог нэг сонинд ажилласан сарыг нөгөөд шилжүүлэн тооцох замаар тогтоож болно.

11. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас зарласан хугацаанд бүртгүүлж чадаагүй ажиллагсад бүртгэх хугацаа дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор өргөдөл гарган нөхөн бүртгүүлж болно.

Гурав. Компанийн нийт хувьцааны тоо, нэгж хувьцааны үнийг тогтоох

12. Бүртгүүлсэн ажилтан тус бүрийн ажилласан сарыг нэмж нийт хугацааг тодорхойлно. Ажилласан сар нь бутархай тоогоор илэрхийлэгдэж байгаа тохиолдолд бутархай тооны орон шилжүүлэх зарчмаар бүхэл оронтой тоонд шилжүүлж гаргана.

13. Компанийн нийт хувьцааны тоог дараахь байдлаар тодорхойлно:

а/ажиллагсдын нийт ажилласан сарыг 100 гэсэн итгэлцүүрээр үржүүлж, компанийн нийт хувьцааны 40 хувьд ногдох хувьцааны тоог тодорхойлно;

б/"а"-д тодорхойлсон тоог 40-д

хувааж 100-гаар үржүүлсэн нь компанийн нийт хувьцааны тоотой тэнцүү байна. Өөрөөр хэлбэл "а"-д тодорхойлсон тоог 40 хувьд харьцуулж нийт хувьцааны тоог тодорхойлно.

14. Тус компанийг хувьчлах доод үнэ (дүрмийн сангийн хэмжээ)-ийг нийт хувьцааны тоонд хуваан нэгж хувьцааны доод үнийг тодорхойлно.

15. Тухайн ажилтны сонинд ажилласан нийт сарыг 100-гаар үржүүлсэн нь түүнд худалдаж авахыг санал болгох хувьцааны тоо болно.

Дөрөв. Давуу эрхээр худалдах хувьцааг санал болгох, худалдах

16. Давуу эрхээр хувьчлалд оролцох эрх бүхий этгээдийн хувьцааны нийт төлбөр нь энэхүү журмын 15 дугаар зүйлд зааснаар тодорхойлогдсон хувьцааны тоог нэгж хувьцааны доод үнээр үржүүлсэнтэй тэнцэнэ.

17. Энэхүү журмын 16 дугаар зүйлд заасан үнээр тухайн этгээдэд ногдох хувьцааг худалдаж авахыг санал болгоно.

18. Төрийн өмчийн хороо нь давуу эрхээр хувьцаа санал болгож худалдахдаа дор дурдсан зүйлийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана:

а/давуу эрхээр хувьчлалд оролцох эрх бүхий этгээдийн нэрс;

б/хүн тус бүрт ногдох хувьцааны тоо;

в/нэгж хувьцааны доод үнэ болон нийт төлбөр;

г/төлбөрийг шилжүүлэх банкны нэр, дансны дугаарууд;

д/төлбөр гүйцэтгэх хугацаа;

е/төлбөрийн баримтыг хүлээн авах газар, хугацаа;

ж/хувьчлалд оролцох давуу эрхээ алдах нөхцөл;

з/төлбөрийг хүчингүйд тооцох нөхцөл;

и/худалдагдаагүй хувьцааг дахин санал болгож худалдах нөхцөл, төлбөр хийх хугацаа;

к/ өмчлөгчийн эрхийг шилжүүлэх нөхцөлүүд;

л/ бусад шаардлагатай мэдээллүүд.

19. Давуу эрхээр хувьчлалд оролцогч этгээд нь түүнд санал болгосон хувьцааг худалдаж авахаас татгалзаж болох бөгөөд санал болгосон хувьцааны тодорхой хэсгийг буюу бүгдийг нь худалдаж авах эрхтэй.

20. Давуу эрхээр хувьцаа худалдан авагч нь худалдаж авах хувьцааныхаа төлбөрийг зарласан хугацаанд төлнө.

21. Зарласан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд тухайн этгээдийг хувьцаа худалдан авахаас татгалзсанд тооцно.

22. Хувьцаа худалдан авахаас татгалзсан, төлбөрөө хийгээгүйн улмаас хувьцаа худалдан авахаас татгалзсанд тооцогдсон, санал болгосон хувьцаанаас тодорхой хэсгийг худалдан авсан зэргээс шалтгаалан худалдагдаагүй үлдсэн хувьцааг хувьцаа худалдан авсан хүмүүст дахин нэг удаа худалдаж авахыг санал болгоно.

Ингэхдээ хамгийн олон сар ажилласан хүнээс эхлэн санал болгож худалдана.

23. Хувьцааг дахин худалдахдаа энэхүү журмын 19 дүгээр зүйлийг баримтална.

24. Ажиллагсдын ажилласан сар нь тэнцүү тохиолдолд тэдгээрийн ажилласан хоногийг харгалзана.

25. Худалдан авагч дахин санал болгосон хувьцааны төлбөрийг заасан хугацаанд төлөх бөгөөд төлбөр хийгдээгүй тохиолдолд худалдан авагчийг дахин санал болгосон хувьцааг худалдан авахаасаа татгалзсанд тооцно.

26. Дахин санал болгосны дараа хувьцаа худалдагдаагүй үлдсэн тохиолдолд тэдгээр хувьцааг компанийн нийт хувьцааны 60 хувь дээр нэмж хязгаартай дуудлагын худалдаагаар худалдана.

Тав. Хувьцааг хязгаартай дуудлагын худалдаагаар худалдах

27. Энэ журмын 26 дугаар зүйлд заасан хувьцааг зургаан тэнцүү багц болгон сонин, хэвлэл эрхлэн гаргадаг хуулийн этгээд, иргэдэд хязгаартай дуудлагын худалдаагаар худалдана.

28. Хязгаартай дуудлагын худалдаагаар худалдах нэгж хувьцааны доод үнийг энэхүү журмын 14 дүгээр зүйлд заасан журмаар тодорхойлно.

29. Багц хувьцаа худалдан авсан этгээд

/хязгаартай дуудлагын худалдаанд оролцогч/ нь нэмж багц хувьцаа худалдан авч болно.

30. Хязгаартай дуудлагын худалдааны доод орлого нь дуудлагын худалдаагаар худалдагдах нийт хувьцааны тоог нэгж хувьцааны доод үнээр үржүүлсэн үржвэртэй тэнцэнэ.

31. Дуудлагын худалдаагаар хувьчлагдаагүй үлдсэн хувьцааг хэрхэх тухай асуудлыг Төрийн өмчийн хороо хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Журам батлах тухай

"Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль"-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг, түүнийг хэрэглэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн улсын хяналтын алба /Ц. ХОРЛООБААТАР/-нд даалгасугай.

3. Хөдөө аж ахуйн яамны /хуучнаар/ коллегийн 1973 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 11 дүгээр протоколоор баталсан Мал эмнэлэг, ариун цэврийн тэмдгүүдийн хэлбэр, хэмжээ, мал эмнэлэг-ариун цэврийн тэмдгүүдийг хэрэглэх зааврыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ч. СОДНОМЦЭРЭН

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын
1999 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/168 тоот тушаалын хавсралт

МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ, БАТАЛГААНЫ ТЭМДЭГ ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилт нь хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангуулах үүднээс мал эмнэлэг-ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг, магадлан шинжилгээ хийх эрх бүхий албад нь мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний чанарын түвшинг шинжлэн дүгнэлт өгөх, зэрэг дугаар тогтоох зорилгоор тусгай индексийн дугаар бүхий мал эмнэлэг, ариун цэврийн Магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийг хэрэглэхтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг нь албан ёсоор батлагдсан тусгай хэлбэр, хэмжээ, загвартай, тэмдгэн доторхи үг нь кирилл эсвэл латин үсгээр, тоо нь арабаар бичээстэй байна.

1.3. Энэ журмын 2.1, 2.2, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.9 дэх хэсэгт заасан хэлбэр, хэмжээ, загвар, бичээс бүхий мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийг хэрэглэх зөвшөөрлийг дараахь шаардлага хангасан мал эмнэлгийн алба, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторит Мал эмнэлгийн улсын хяналтын төв албанаас олгоно.

1.3.1. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлыг нэг буюу хэд хэдэн үзүүлэлтийг холбогдох стандартын дагуу үнэн зөв, зохих магадлалтайгаар тодорхойлох, сорилт, туршилт, шинжилгээ хийх чадвартай нь тогтоогдсон эрх бүхий мал

эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний лаборатори,

1.3.2. Мал эмнэлгийн олон талт ажил үйлчилгээг зах зээлийн хүрээнд бизнес, эдийн засгийн мэдлэгтэйгээр зохион байгуулан хэрэгжүүлж чадах нь батлагдсан, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээг хийх эрх бүхий лабораторитой мал эмнэлгийн байгууллага,

1.4. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн индексийг аймгийн мал эмнэлэг, ариун цэврийн лабораторит цагаан толгойн үсгийн дэс дарааллаар, хувийн мал эмнэлгийн байгууллагын мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний лабораторит аймгийн индексийн дугаарын ард тусгай цифрээр, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний лабораторит итгэмжлэгдсэн гэрчилгээ авсны дэс дарааллаар тус тус тэмдэглэнэ.

1.5. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийг Мал эмнэлгийн улсын хяналтын төв албаны зөвшөөрлөөр хийлгэж олгоно.

1.6. Мал эмнэлгийн мэргэжил эзэмшээгүй хүн мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг эзэмших эрхгүй.

1.7. Хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд /мах, махан бүтээгдэхүүн, өндөг/ зэрэг дугаарын болон махны төрлийг тодорхойлох тэмдгийг тусгайлан эрх олгогдсон малын их эмч дарна.

Хоёр. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, Баталгааны тэмдэг, хэлбэр, хэмжээ, загвар

2.1. <<Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгаа>> гэсэн бичээстэй, төв хэсэгтээ тусгай индексийн дугаартай 4,5x4,5 см-ийн хэмжээтэй адил талт гурвалжин тэмдгийг мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл мэндийн гэрчилгээнд дарна. Нийлэг уут, модон торх, шуудай, хайрцагт хийсэн мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд уг баталгааны тэмдгийг 5x6 см-ийн хэмжээтэй цаас эсвэл дөрвөлжин модон дээр дарж түүнийг бөх батаар наах буюу зүүнэ.

2.2. Монгол улсаас гадаад оронд экспортлож буй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээлд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийж баталгаажуулах

эрх бүхий итгэмжлэгдсэн мал эмнэлгийн алба, лаборатори нь 6,5x4,5 см-ийн хэмжээтэй, зуйван дугариг хэлбэртэй /үсгийн өндөр нь 0.8 см, тооны өндөр нь 1 см/ мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг хэрэглэнэ. Уг баталгааны тэмдгийн дотор талын дээд хэсэгт мах экспортлогч орны нэр "MONGOLIA", дунд хэсэгт мал эмнэлгийн алба, лабораторийг төлөөлөх тусгай индексийн дугаар, доод хэсэгт "VET. INSPECTOR" гэсэн бичээстэй байна.

2.3. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг нь энэ журмын 1,2,3 дугаар хавсралтаар баталсан индексийн дугаартай байна.

2.4. Өндгөнд үйлдвэрлэгчийн оноосон



нэрийг төлөөлөх тусгай индексийн дугаар бүхий 2x0,5 см-ийн хэмжээтэй, хэвтээ дөрвөлжин хэлбэртэй мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг хэрэглэнэ.

2.5. Гулууз маханд дарах мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг нь хэлбэрийн хувьд махны чанар, зэрэг дугаарыг тодорхойлохоос гадна мал эмнэлэг-ариун цэврийн үзлэг, магадлан шинжилгээ хийснийг гэрчлэх тухайн мал эмнэлгийн байгууллага, лабораторийг төлөөлөх тусгай индексийн дугаартай байна.

2.6. нэгдүгээр зэргийн гулууз маханд "мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгаа" гэсэн бичээстэй, төв хэсэгтээ мал эмнэлгийн байгууллага, лабораторийг төлөөлөх тусгай индексийн дугаар бүхий 4 см-ийн голчтой дугуй хэлбэртэй,

2.7. Хоёрдугаар зэргийн гулууз маханд "Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгаа" гэсэн бичээстэй, төв хэсэгтээ мал эмнэлгийн байгууллага, лабораторийг төлөөлөх тусгай индексийн дугаар бүхий 4x4 см-ийн хэмжээтэй "дөрвөлжин" хэлбэртэй,

2.8. гуравдугаар зэргийн гулууз маханд "Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгаа" гэсэн бичээстэй, төв хэсэгтээ мал эмнэлгийн байгууллага, лабораторийг төлөөлөх тусгай индексийн дугаар бүхий 4,5x4,5 см-ийн хэмжээтэй "адил талт мохоо өнцөгт гурвалжин" хэлбэртэй баталгааны тэмдгийг тус тус хэрэглэнэ.

Гурав. Хяналт, шалгалт, хариуцлага

3.1. Энэ журмын хэрэгжилтэнд орон нутгийн засаг захиргаа, төрийн хууль хяналтын байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид эрхийн дагуу хяналт тавина.

3.2. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийг алдаж үрэгдүүлбэл 3 хоногийн дотор цагдаагийн байгууллага, Мал эмнэлгийн улсын хяналтын төв албанд мэдэгдэнэ. Уг тэмдгийг дахин шинээр хийлгэсэн тохиолдолд тусгай тэмдэглэл хөтөлнө. Алдагдсан баталгааны тэмдэг олдвол түүнийг дахин хэрэглэхгүй.

3.3. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн үсэг, тоо, хэлбэр бүдгэрч хэрэглэх боломжгүй, гэмтэлтэй, анхны загвараас дардас нь зөрүүтэй болсон тохиолдолд акт тогтоож хүчингүй болсныг зарлана. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг эзэмшигч нь түүнийг бөх бат саванд хадгална.

3.4. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн хэлбэр хэмжээ, үсэг, дугаарыг дур мэдэн

2.9. Тэмээ, адуу, үхэр, хонь, ямааны гулууз маханд мал эмнэлэг-ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийг дараахь байрлалаар дарна.

2.9.1. Бод малын /буга орно/ гулууз махны өгзөгний орчим, далны гадна талд.

2.9.2. Бог болон гахайн гулууз махны дал, гуяны өгзөгний орчим гадна талын хэсэгт өрөөлдөж,

2.9.3. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгаагаар стандартын шаардлага хангахгүй байгаа гулууз махны дал, гуяны гадна талд 1,5x2 см-ийн хэмжээтэй "СБ" үсгэн баталгааны тэмдгийг өрөөлдөж,

2.9.4. Бүх төрлийн малын төлийн гулууз махны дал, гуяны гадна талд 1,5x2 см-ийн хэмжээтэй "Т" үсгэн баталгааны тэмдгийг зэрэг, дугаарын тэмдгийн баруун гар талд.

2.9.5. Засаатай болон асман малын гулууз махны дал, гуяны гадна талд 1.2x1.2 см-ийн хэмжээтэй "Б" үсгэн баталгааны тэмдгийг зэрэг дугаарын тэмдгийн баруун гар талд.

2.9.6. Адууны махыг бусад төрлийн мал, амьтны махнаас ялгахын тулд 3.0x3.5 см-ийн хэмжээтэй "А" үсгэн баталгааны тэмдгийг зэрэг дугаарын тэмдгийн баруун гар талд.

2.9.7. Яманы махыг бусад төрлийн мал, амьтны махнаас ялгахын тулд 2.0x2.5 см-ийн хэмжээтэй "Я" үсгэн баталгааны тэмдгийг зэрэг дугаарын тэмдгийн баруун гар талд.

2.9.8. Мал эмнэлэг-ариун цэврийн шаардлага хангаагүй, хүнсний хэрэгцээнд тэнцэхгүй мах, махан бүтээгдэхүүнд 4.0x2.5 см-ийн хэмжээтэй "У" үсгэн баталгааны тэмдгийг гуя, далны гадна талд өрөөлдөж тус тус дарна.

өөрчилсөн, эсвэл хуурамчаар үйлдсэн, тэмдгийг хэрэглэх журмыг зөрчсөн гэмт этгээдэд "Захиргааны хариуцлагын тухай", "Эрүүгийн тухай" хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.5. Байгууллага нь өөрчлөгдсөний улмаас ашиглахгүй болсон мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийг Мал эмнэлгийн улсын хяналтын төв албанд заавал хураалгана.

3.6. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийг загварын дагуу цагдаагийн байгууллага хийж бүртгэн дардсыг авч захиалагчдад олгоно. Харин уг тэмдгийг гадаадад түүнчлэн цагдаагийн бус байгууллагаар хийлгэхийг хориглоно.

3.7. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийг бусад байгууллага хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

3.8. Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг түүнийг хэрэглэх журам-ыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг түүнийг хэрэглэх журмын 1-р хавсралт

Аймаг, хот, сум, дүүргийн мал эмнэлгийн албадын мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн индексийн дугаар

Д/д	Индексийн дугаар		Аймагийн индексийн дугаар	Сумын индексийн дугаар	Д/д	Индексийн дугаар		Аймагийн индексийн дугаар	Сумын индексийн дугаар
	Аймаг, дүүрэг, сумын нэр	Архангай				Аймаг, дүүрэг, сумын нэр	Индексийн дугаар		
1.		Архангай	01		6	Бүрэт			02-06
					7	Дэлүүн			02-07
					8	Ногооннуур			02-08
1	Батцэнгэл			01-01	9	Сагсай			02-09
2	Булган			01-02	10	Толбо			02-10
3	Жаргалант			01-03	11	Улаанхус			02-11
4	Их тамир			01-04	12	Цэнгэл			02-12
5	Өгийнуур			01-05	13	Өлгий			02-13
6	Өлзийт			01-06					
7	Өндөрүлаан			01-07	3.	Баянхонгор	03		
8	Тарваг			01-08					
9	Төвшрүүлэх			01-09	1	Баянцагаан			03-01
10	Хайрхан			01-10	2	Баянбулаг			03-02
11	Хангай			01-11	3	Баянговь			03-03
12	Хашаат			01-12	4	Баянлиг			03-04
13	Хотонт			01-13	5	БаянОвоо			03-05
14	Цахир			01-14	6	БаянӨндөр			03-06
15	Цэнхэр			01-15	7	Баянцагаан			03-07
16	Цэцэрлэг			01-16	8	Богд			03-08
17	Чулуут			01-17	9	Бөмбөгөр			03-09
18	Эрдэнэбулга			01-18	10	Буцагаан			03-10
19	Эрдэнэмандал			01-19	11	Галуут			03-11
2.		Баянөлгий	02		12	Гурванбулаг			03-12
					13	Жаргалант			03-13
					14	Жинст			03-14
1	Алтай			02-01	15	Заг			03-15
2	Алтанцогц			02-02	16	Өлзийт			03-16
3	Баяннуур			02-03	17	Хүрээмарал			03-07
4	Бугат			02-04	18	Шинэжинст			03-18
5	Булган			02-05	19	Эрдэнэцогт			03-19

4.	Булган	04			15 Чандмань 16 Шарга 17 Эрдэнэ		05-15 05-16 05-17
1	Баянагт		04-01				
2	Баянуур		04-02				
3	Бугат		04-03				
4	Булган		04-04		6. Говьсүмбэр	06	
5	Бүрэгхангай		04-05		1 Баянтал		06-01
6	Гурванбулаг		04-06		2 Сүмбэр		06-02
7	Дашинчилэн		04-07		3 Шивээговь		06-03
8	Могод		04-08				
9	Орхон		04-09		7. Дархан-Уул	07	
10	Рашаант		04-10				
11	Сайхан		04-11		1 Дархан		07-01
12	Сэлэнгэ		04-12		2 Орхон		07-02
13	Төшиг		04-13		3 Хонгор		07-03
14	Хангал		04-14		4 Шарынгол		07-04
15	ХишигӨндөр		04-05				
16	ХутагӨндөр		04-16		8. Дорноговь	08	
5.	Говь-Алтай	05			1 Айраг		08-01
					2 Алтанширээ		08-02
1	Алтай		05-01		3 Даланжаргалан		08-03
2	Баян-Уул		05-02		4 Дэлгэрэх		08-04
3	Бигэр		05-03		5 Июэт		08-05
4	Бугат		05-04		6 Мандах		08-06
5	Дарви		05-05		7 Өргөн		08-07
6	Дэлгэр		05-06		8 Сайншанд		08-08
7	Жаргалан		05-07		9 Сайхандулаан		08-09
8	Тайшир		05-08		10 Улаанбадрах		08-10
9	Тонхил		05-09		11 Хатанбулаг		08-11
10	Төгрөг		05-10		12 Хөвсгөл		08-12
11	Халиун		05-11		13 Эрдэнэ		08-13
12	Хөхморьт		05-12				
13	Цогт		05-13		9. Дорнод	09	
14	Цээл		05-14				

1	Баяндун				1	Алдархаан		11-01
2	Баянтүмэн				2	Асгат		11-02
3	Баянуул				3	Баянхайрхан		11-03
4	Булган				4	Бангэс		11-04
5	Гурванзагал				5	Булай		11-05
6	Дашбалбар				6	Дөрвөлжин		11-06
7	Матад				7	Завханмандал		11-07
8	Сэргэлэн				8	Идэр		11-08
9	Халхгол				9	Их-Уул		11-09
10	Хөлөнбуйр				10	Нөмрөг		11-10
11	Хэрлэн				11	Отгон		11-11
12	ЦагаанОвоо				12	Сантмаргз		11-12
13	Чойбалсан				13	Сонгино		11-13
14	Чулуунхороот				14	Түдэвтэй		11-14
10.	Дундговь	10			15	Тэлмэн		11-15
					16	Тэс		11-16
1	Адаацаг				17	Улиастай		11-17
2	Баянжаргалан				18	Ургамал		11-18
3	Говь-Угтаал				19	Цагаанхайрхан		11-19
4	Гурвансайхан				20	Цагаанчулуут		11-20
5	Дэлгэрхангай				21	Цэцэн-Уул		11-21
6	Дэлгэрцогт				22	Шилүүстэй		11-22
7	Дэрэн				23	Эрдэнэхайрхан		11-23
8	Луус				24	Яруу		11-24
9	Мандалговь				12.	Орхон	12	
10	Өлзийт				10-01			
11	Өндөршил				10-02			
12	Сайнцагаан				10-03			
13	СайханОвоо				10-04			
14	Хулд				10-05			
15	Цагаандэлгэр				10-06			
16	Эрдэнэдалай				10-07			
					10-08			
					10-09			
					10-10			
					10-11			
					10-12			
					10-13			
					10-14			
					10-15			
					10-16			
					13.	Өвөрхангай	13	
11.	Завхан	11			1	БаянӨндөр		12-01
					2	Жаргалант		12-02
					3	Баянгол		
					1	Баруунбаянгуулан		13-01
					2	Бат-өлзий		13-02
					3	Баянгол		13-03

4	Баян-Өндөр	13-04	1	Асгат	15-01
5	Богд	13-05	2	Баяндэлгэр	15-02
6	Бурд	13-06	3	Баруунурт	15-03
7	Гучин-Ус	13-07	4	Дарьганга	15-04
8	Зүйл	13-08	5	Мөнхаан	15-05
9	Зүүнбаянгулаан	13-09	6	Наран	15-06
10	Нарийнтгээл	13-10	7	Онгон	15-07
11	Өлзийт	13-11	8	Сүхбаатар	15-08
12	Сант	13-12	9	Түвшинширээ	15-09
13	Тарагт	13-13	10	Түмэнцогт	15-10
14	Төгрөг	13-14	11	Уулбаян	15-11
15	Уянга	13-15	12	Халзан	15-12
16	Хайрхандулаан	13-16	13	Эрдэнэцагаан	15-13
17	Хархорин	13-17			
18	Хужирт	13-18	16.	Сэлэнгэ	16
14.	Өмнөговь	14			
1	Баяндалай	14-01	1	Алтанбулаг	16-01
2	БаянОвоо	14-02	2	Баруунбүрэн	16-02
3	Булган	14-03	3	Баянгол	16-03
4	Гурвантэс	14-04	4	Ерөө	16-04
5	Даланзадгад	14-05	5	Жавхланта	16-05
6	МандалОвоо	14-06	6	Зүүнбүрэн	16-06
7	Манлай	14-07	7	Мандал	16-07
8	Новн	14-08	8	Орхон	16-08
9	Номгон	14-09	9	Орхонтүүл	16-09
10	Сэвэрэй	14-10	10	Сайхан	16-10
11	Ханбогд	14-11	11	Сант	16-11
12	Ханхонгор	14-12	12	Сүхбаатар	16-12
13	Хурмэн	14-13	13	Түшиг	16-13
14	ЦогтОвоо	14-14	14	Хушаат	16-14
15	Цогцэций	14-15	15	Хүдэр	16-15
			16	Цагааннуур	16-16
			17	Шаммар	16-17
15.	Сүхбаатар	15	17.	Төв	17

1	Алтанбулаг	17-01	6	Зүүнхангай	18-06
2	Аргалант	17-02	7	Малчин	18-07
3	Архуст	17-03	8	Наранбулаг	18-08
4	Батсүмбэр	17-04	9	Өлгий	18-09
5	Баян	17-05	10	Өмнөговь	18-10
6	Баяндэлгэр	17-06	11	Өндөрхангай	18-11
7	Баянжаргалан	17-07	12	Сагил	18-12
8	Баянжүүл	17-08	13	Тариалан	18-13
9	Баянхангай	17-09	14	Түргэн	18-14
10	Баянчандмань	17-10	15	Тэс	18-15
11	Баянцагаан	17-11	16	Улаангом	18-16
12	Баянцогт	17-12	17	Хархираа	18-17
13	Борнуур	17-13	18	Ховд	18-18
14	Бүрэн	17-14	19	Хяргас	18-19
15	Далгэрхаан	17-15	20	Цагаанхайрхан	18-20
16	Жаргалант	17-16			
17	Завсар	17-17	19.	Ховд	19
18	Зүүнмод	17-18			
19	Лүн	17-19	1	Алтай	19-01
20	Мөнхморьт	17-20	2	Булган	19-02
21	Өндөрширээт	17-21	3	Баянт	19-03
22	Сүмбэр	17-22	4	Дарви	19-04
23	Сэргэлэн	17-23	5	Доргөн	19-05
24	Угтаалцайдам	17-24	6	Дуут	19-06
25	Цэцэг	17-25	7	Жаргалант	19-07
26	Эрдэнэ	17-26	8	Зэрэг	19-08
27	Эрдэнэсант	17-27	9	Манхан	19-09
18.	Увс		10	Мөнххайрхан	19-10
			11	Мөст	19-11
			12	Мангад	19-12
1	Баруунгуруун	18-01	13	Уянч	19-13
2	Бохморён	18-02	14	Ховд	19-14
3	Давст	18-03	15	Цэцэг	19-15
4	Завхан	18-04	16	Чандмань	19-16
5	Зүүнговь	18-05	17	Эрдэнэбүрэн	19-17

№	Хөвсгөл	20	21	22	23	24	25
1	Алагзэдэнэ	20-01					
2	Арбулаг	20-02					
3	Баянзүрх	20-03					
4	Бүрэнтогтох	20-04					
5	Галт	20-05					
6	Жаргалант	20-06					
7	Их-уул	20-07					
8	Мөрөн	20-08					
9	Рашаант	20-09					
10	Ренчинлхүмбэ	20-10					
11	Тариалан	20-11					
12	Тосонцэнгэл	20-12					
13	Төмөрбулаг	20-13					
14	Түнэл	20-14					
15	Улаан-уул	20-15					
16	Ханх	20-16					
17	Хатгал	20-17					
18	Цагааннуур	20-18					
19	Цагаануул	20-19					
20	Цагаан ур	20-20					
21	Цэцэрлэг	20-21					
22	Чандманьөндөр	20-22					
23	Шинэ-ндэр	20-23					
24	Эрдэнэбулган	20-24					
21.	Хэнтий	21					
1	Батноров	21-01					
2	Батширээт	21-02					
3	Баян-адрага	21-03					
4	Баянмөнх	21-04					
5	БаянОвоо	21-05					
6	Баянхутаг	21-06					
7	Бяндэр						21-07
8	Галчэр						21-08
9	Гурванбаян						21-09
10	Дадал						21-10
11	Дархан						21-11
12	Дэлгэрхаан						21-12
13	Жаргалтхаан						21-13
14	Мөрөн						21-14
15	Норовлин						21-14
16	Өлзийт						21-16
17	Өмнөдэлгэр						21-17
18	Хэрлэн						21-18
19	Цэнхэрмандал						21-19
22.	Улаанбаатар						22
1	Баянзүрх						22-01
2	Багахангай						22-02
3	Баянгол						22-03
4	Баянзүрх						22-04
5	Гачуурт						22-05
6	Жаргалант						22-06
7	Налайх						22-07
8	Сонгинохайрхан						22-08
9	Сүхбаатар						22-09
10	Туул						22-10
11	хан-уул						22-11
12	Чингэлтэй						22-12

Тайлбар: Сумын мал эмнэлэг, үржлийн албаны улсын үйлдвэрийн газар хувийн мал эмнэлэг болсон тохиолдолд уг сумын мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн индексийн дугаарыг эзэмшинэ.



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2000 он № 3 (141)

Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг түүнийг хэрэглэх журмын 2-р хавсралт

Мах экспортлох бүрэн эрхтэй махны үйлдвэрийн дэргэдэх мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний лабораторийн мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн индексийн дугаар

№	Баталгааны тэмдгийн индекс		Индексийн дугаар
	Мах боловсруулах үйлдвэрийн нэр		
1	Мах импэкс		001
2	Дорнод		002
	Дархан-Экспо		003
3	Мөнгөн-Алтай		004
4	Дорнын говь		005
5	Бор-Өндөр		006
6	Завхан		007
7	Багахангай		008
8	Орхон-Бэлчир		009
9	Буянт-Катун		0011

Мал эмнэлэг, ариун цэврийн
магадлан шинжилгээ, баталгааны
тэмдэг түүнийг хэрэглэх журмын
3-р хавсралт

Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторийн мал эмнэлэг, аруун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдгийн индексийн дугаар

Д/Д	Индекс	Индексийн дугаар
1	Лабораторийн нэр Нийслэлийн мал эмнэлгийн хяналтын албаны нян- ийлдэс судлал, ариун цэврийн магадлан шинжилгээний лаборатори	Л-1
2	Хүчит-Шонхор ХХК-ний дэргэдэх мал эмнэлгийн нян-ийлдэс судлал, ариун цэврийн лаборатори	Л-2
3	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	Л-3

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гарган
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

№ 329612
Индекс 14003

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйт
эрхтэй газрын харьяат хэвлэл
ийлдэжгэ хэвлэл

№ 327806,
320407